



ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР



БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ



"БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ" 2017 ОНЫ
ГАР ЗУРАГ, ЗОХИОН БИЧЛЭГ, ШУЛГИЙН УЛСЫН УРАЛДААНЫ
ШИЛДЭГ БҮТЭЭЛҮҮДИЙН ЦОМОГ

БИ ГЭР БҮЛДЭЭ
ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ



"БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ" 2017
ГАР ЗУРАГ, ЗОХИОН БИЧЛЭГ, ШУЛГИЙН УЛСЫН ҮРАЛДААНЫ
ШИЛДЭГ БҮТЭЭЛҮҮДИЙН ЦОМОГ

ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ ОУБЫН
ХҮХДИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛАЛ ХӨТӨЛБӨР



МЭНДЧИЛГЭЭ



Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллага нь гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, гэр бүлийн үнэ цэнэ, эцэг эхийн хүүхэддээ хандах хандлагыг дээшлүүлэхэд хүүхдийн дуу хоолойг сонсох зорилгоор "Би гэр бүлдээ үүнийг хүсдэг" гар зураг, шүлэг, зохион бичлэгийн уралдааныг зохион байгуулж ирсэн. Энэхүү уралдаан нь Хүүхдийн Хөгжил Хамгаалал Хөтөлбөрийн санаачлагаар 2002 оноос эхлэн зохион байгуулагдсан ба хүүхдүүдийн идэвхтэй оролцдог нэр хүндтэй үндэсний хэмжээний уралдаан болсон юм. Энэ жилийн уралдааныг гэр бүлийн радио FM 104.5, Гэр Бүл Хүүхэд Залуучуудын Хөгжлийн газартай хамтран зохион байгуулж байгаа бөгөөд эхний шатанд нийт 21 аймаг, 9 дүүргийн 5000 хүүхэд бүтээлээ ирүүлснээс 2-р шатанд 1000 гаруй бүтээл шалгарсан байна.

Уралдаанд идэвхтэй оролцсон нийт хүүхдүүддээ болон амжилттай хамтран зохион байгуулсан байгууллагууддаа чинь сэтгэлээсээ талархал илэрхийлье.

Гэр бүл бүхэн баяр хөөр, аз жаргалаар дүүрэн байг!

Хүндэтгэсэн

Филип Ийвэрт
Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын суурин төлөөлөгч

Хүүхэд бүрийн сайн сайхны төлөө



ГЭР БҮЛ, ХҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

МЭНДЧИЛГЭЭ



Гэр бүл нь хүний хөгжлийн анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж, аж төрөх ёсны бичил ахуй, соёл иргэншилийн хамгийн түгээмэл институт юм. Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Монгол гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, бат бөх хариуцлагатай гэр бүлийг дэмжин, хүүхдийн эрхийг дээдэлж, залуучуудыг хөгжих, суралцах, хөдөлмөрлөх таатай орчин нөхцөлөөр хангана” гэсэн зорилт дэвшүүлсэн.

Гэр бүлд сууринласан хөгжил, хамгааллын бодлого гэсэн үзэл хандлагад үндэслэн төрөөс гэр бүлийн эрхийг хамгаалах, дэмжих, иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн хүрээнд хүүхдийн эрх, хамгааллын асуудалд эцэг эх, асран хамгаалагч, харгалzan дэмжигчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлага байна.

Монголын гэр бүлийн сайн сайхан байдлыг хангахын тулд эрх зүйн орчны өөрчлөлт, шинэчлэлийг нийгмийн хамгийн үнэ цэнэтэй, нөөц баялаг болсон хүүхэд, залуусын эрх, ашиг сонирхолд хандуулж Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн төслүүд олон нийтээр хэллэлцэгдэж байна.

Дэлхий нийтээр жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрийг Олон улсын Гэр бүлийн өдөр болгон тэмдэглэдэг. Энэхүү өдрийн хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн Зөн Монгол ОЛОН УЛСЫН-байгууллага, Гэр бүлийн радио 104.5 хамтран “Би гэр бүлдээ үүнийг л хүсдэг” хүүхдийн гар зураг, шүлэг, зохион бичлэгийн улсын уралдааныг 12 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

“Би гэр бүлдээ үүнийг л хүсдэг” уралдаанд ирүүлсэн бүтээл бүхэн өнөөгийн нийгэмд бидний хүүхдүүд гэр бүлдээ юуг хүсж мөрөөддөг, тэдний бяцхан ертөнцөд гэр бүлийн аз жаргал хэрхэн төсөөлөгддөгийг харж болно. Тэд бүтээлээрээ дамжуулан гэр бүлийн халуун дулаан хайр халамж, элэг бүтэн, амар амгалан амьдрал чухал гэдгийг илэрхийлжээ.

Хамгийн гайхалтай нь гэр бүл, эцэг эх нь хэн ч байсан хүүхэд бүр аав ээждээ, гэр бүлдээ ХАЙРТАЙ гэж ам бардам хэлж, томчууд бидний амьдралынхаа явцад гаргадаг алдаа дутагдлыг балчир ухаандаа шүүн тунгааж, уужуу сэтгэлээр училдаг нь бахархмаар байсныг онцлох ёстой.

Монгол орны өнцөг булан бүрээс 5000 гаруй бүтээлээр гэр бүлийнхээ амьдралын онцлог үйл явдал, зэрэг сөрөг зан харилцаа болон хүсэл мөрөөдөл, нандин сэтгэлээ бидэнд илэн далангүй нээж, санал бодлоо хуваалцсан нийт уралдаанд оролцсон дэмжиж оролцсон хүүхдүүд,, эцэг, эхчүүддээ талархлаа илэрхийлье.

Амьдралын утга учир болсон алаг хөөрхөн үрстэйгээ аз жаргалыг хамтдаа бүтээцгээе.

Хүндэтгэсэн

О.АЛТАНСҮҮХ

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА



МЭНДЧИЛГЭЭ



Аз жаргалтай гэр бүлийн амьдралыг хүн бүр хүсдэг. Тэр тусмаа бидний үргэлжлэл, таны тусгал болсон бяцхан хүүхдүүд Үүнийг л зөвхөн гэр бүлдээ хүсч байдаг. Тэгвэл тэдний энэ хүсэл мереөөдлийг заримдаа томчууд бид анзаардаггүй. Тэдний ертөнцөд яг юу болж байна вэ? Үнэндээ үүнийг мэдэх боломж бидэнд үргэлж байдаг. Харин тэр боломж нь юу вэ?... Одоогоос арван дөрвөн жилийн өмнө Гэр бүлийн радио FM 104.5-ын хамт олон "Би гэр бүлдээ үүнийг л хүсдэг" хүүхдийн зохион бичлэгийн уралдааныг санаачлан Дэлхийн Зөн-Монгол" ОУБ-тай хамтран орон даяар зарласан юм. Гараа сайн бол бария сайн гэдэг. Өнөөдөр энэ уралдаанд монгол орны өнцөг булан бүрээс хүүхдүүд идэвхтэйгээр оролцдог болсонд туйлын талархалтай байна. Тиймээс өдийг хүртэл итгэмжтэйгээр хамтран ажилласан "Дэлхийн Зөн Монгол" ОУБ-ын хамт олондоо Гэр бүлийн радио FM 104.5-ын үе үеийн уран бүтээлчдийн өмнөөс гүн хүндэтгэл, талархалыг дэвшүүлье.

Монгол Гэр бүлийн сайн сайхны төлөө үйлчилдэг манай хамт олон, эфирийн дуугаралтаа эхэлсэн цагаас нийгмийн эерэг уур амьсгалыг дэмжсэн иргэдийн дуу хоолой болж, тэдэнд эерэг нелөөллийг үзүүлэх бүхий л үйл ажиллагааг зохион байгуулсаар ирсэн. Түүний нэг нь жил бүрийн 5-р сарын 15-нд тохиодог Олон Улсын Гэр Бүлийн өдөр юм. Бид 2003 оноос эхлэн тус өдрийг Гэр бүлүүдтэйгээ хамт тэмдэглэж 14 жилийг ардаа үлдээсэн байна. Энэ хугацаанд бат бэх гэр бүлийн үнэ цэнийг сурталчилж, тунхагласан нийтлэл нэвтрүүлэг, олон нийтийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулсан байдаг. Тухайлбал:

- 2003-2017 онд "Би гэр бүлдээ үүнийг хүсдэг" гар зураг, зохион бичлэг, шүлгийн уралдааныг санаачлан ДЗОУБ-тай хамтран орон даяар зохион байгуулсан
- 2006 онд 1000 эр хүний алхааг зохион байгуулж, эрчүүдийн хариуцлагыг нийгэмд өргөсөн
- 2010-2011 онд "Амралтын өдрийг гэр бүлдээ" олон нийтийн үйл ажиллагаа
- 2012-2013 онд "Амдралын ханьдаа үнэнч байя" олон нийтийн үйл ажиллагаа
- 2014 онд бат бэх гэр бүлийн төлөөх "Салалт шийдэл биш" зорилтот төсөл
- 2015 онд хүүхдийг сонсдог хүчирхийлэлгүй ирээдүйн төлөөх "Бидний үргэлжлэл" зорилтот төсөл
- 2016-2017 онд эрчүүдийн үнэ цэнэ үнэлээмжийг нийгэмд өсгөх "Монгол Аав" төслийг тус тус амжилттай хэрэгжүүлсэн байна.

Харин энэ жилийн хувьд гэр бүлийн боловсрол олгох "Хос урлаг" edutainment нэвтрүүлгийн байнгын сонсогчдын зохиосон "Хос урлаг" зүйр цэцэн үгсийн эмхтгэл номоор монгол гэр бүлүүдэд бэлэг барихаар боллоо. Нэг сарын хугацаанд нийтдээ 230 гаруй сонсогч, хүний амьдралын алдаа оноо, жаргал зовлонг дэнслэн шигтгэсэн нэг мянга хоёр зуун жаран таван "ЗҮЙР ЦЭЦЭН ҮГС" ийг ирүүлжээ. Энэ бол тэр чигтээ монгол түмний оюун ухааны өв баялаг юм. Тиймээс бид зүйр цэцэн үг бүрийг эмхтгэж, сонсогчдынхоо хамт "Хос Урлаг" хэмээх нэгэн номыг бүтээсэндээ туйлын баяртай байна. Орчин цагийн Монгол хүний амьдралын өнгө аяс, онч цэцэн үгсээс бүтсэн "Хос урлаг" ном нь бидний гэрэлт ирээдүй болсон хүүхдүүдэд оюуны маш том өв баялаг болж очно гэдэгт итгэлтэй байна.

Монголын ирээдүй гэрэлтэй байг!!!

Эрүүл харилцаа

Ивээгдсэн гэр бүл

Эвлэрсэн нийгэм



Хамтлагын 20 жилийн ойн

ӨМНӨХ ҮГ

Дэлхийн улс орнууд болон Монгол улс жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрийг “Гэр булийн өдөр” болгон тэмдэглэн өнгөрүүлдэг.

Энэ өдрийг тохиолдуулан хүүхэд бүрийг гэр бүл, нийгмийн ээлтэй орчинд хүчирхийллэлээс ангид өсөхөд олон нийтийн ойлголт хандлагыг өөрчлөх, нийгмийн амьдралын үнэт нэгж болсон гэр бүл дэх хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс Гэр булийн радио FM-104.5-аас 2002 онд анх санаачлан Дэлхийн Зөн- Монгол Олон Улсын Байгууллагын Төлөөлөгчийн газрын “Хүүхдийн Хөгжил Хамгаалал” хөтөлбөр хамтран “БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ” хүүхдийн гар зураг, шүлэг, зохион бичлэгийн улсын уралдааныг уламжлал болгон жил бүр олон олон байгууллагуудтай хамтран зохион байгуулсаар ирсэн.

Бид уламжлал ёсоор энэ жил 12 дах удаагийн БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСНЭ гар зураг, зохион бичлэг, шүлгийн уралдааныг ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫГ ХӨГЖЛИЙН ГАЗАР, ГЭР БУЛИЙН РАДИО 104.5, ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА ХАМТРАН улсын хэмжээнд зарлан уралдааны 1-р шатанд 5000 гаруй бүтээл, 2-р шатанд 1000 гаруй бүтээлээс шалгаруулалт хийж шагналт байранд орсон 24 бүтээлийг нийтлэв.

Энэ жилийн уралдаанд 21 аймаг, 9 дүүргийн нийт 5-18 насны хүүхдүүд өргөнөөр оролцсон ба хүүхдүүдийн бүтээлээс өнөөгийн улс орны нөхцөл байдал, гэр бүл дэх асуудлууд, хүүхдүүдийн гэгээн өртөнцийөөр аялах, хүсэл мөрөөдлөө бичсэн зохион бичлэг, шүлгээс үншиж, зурсан зургаас нь харж болно.

Гэр булийн хүчирхийллийг буруулах, зөрчлийг арилгахад хүүхдүүдийн дуу хоолойг томчуудад сонсгох, хүүхэд хүсэл мөрөөдлөө чөлөөтэй илэрхийлэхэд боломжийг олгосон уг уралдаанд хүүхдүүд оролцох дуртай болсон нь бидний хийсэн ажлын үр дүн билээ.

“Хүүхэд нас” гэдэг нь хүний амьдралын хамгийн чухал үе юм. Хүүхэд наасаа хэрхэн яж өнгөрөөсөн нь ирээдүйд хэн болох вэ гэдэгтэй салшгүй холбоотой. Иймээс өнөөдрийн хүүхэд нас маргаашийн эх орны ирээдүйн эзэд юм.

“Гэр бүл”-ийг тухайн нийгмийн толь гэдэг. Түүнчлэн гэр бүл нь хүний амьдралын хамгийн сайхан, сэтгэл хангалиун байх орчин, амжилт бүтээлийн эхний гарaa бөгөөд үр хүүхдүүдээ аз жаргалтай байгааг нь харан амьдралаас баяр хөөрийг аваарай.

Монголын бүх гэр бүлүүдэд эрүүл энх, элэг бүтэн, хүүхдийн цангисан инээдээр дүүрэн байхыг хүсэн өрөөе.

Уралдааныг зохион байгуулсан багийн хамт олноос



ШУЛГИЙН ТӨРӨЛ

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ

Аминаасаа тасчин амь төрүүлсэн
 Амандаа уяхан бүүвэй аялсан
 Энгэрээс нь хүртэл сүү асгардаг
 Энэ бурхны элчийг би ээжээ гэдэг
 Алаг хорвоод хүн болж төрөхөд минь
 Алган дээрээ өргөөд нулимыс дуслуулсан
 Анх хэлд ороод хэлсэн тэр л алдартан
 Аугаа их хатан зоригтныг би ааваа гэдэг.
 Хорвоо дэлхийтэй дөнгөж л танилцаж байгаа
 Хосгүй бүхнийг одоо л тольдож байгаа
 Ховорхон заясан хөөрхөн жижигхэн хүмүүс
 Хонгорхон тэднийгээ би дүүгээ гэдэг.
 Амжилтыг аз жаргал гэж эндүүрэлгүй
 Алтнаас түрүүнд ар гэрээ эрхэмлэдэг
 Алаг хорвоод аз жаргалтай амьдраасай
 Амьдралын үнэ цэнийг мэдрээсэй гэж хүсдэг !
 Өвдөж шаналлаа гэж төвөг удалгүй
 Өрд орж тусыг нь усаар хариулалгүй
 Өсгөж, төрүүлсэн ачийг нь үл хайхралгүй
 Хүн шиг хүн болоосой гэж дүү нартаа хүсдэг!
 Хорт шингэнд толгойгоо мэдуулсэн аавтай
 Хоёр нүдэндээ нулимыс дүүрэн үрстэй
 Хорвоод гомдсондоо зүрхгүй болчихсон ээжтэй
 Хэлэхэд ч бэрх, амьдралыг би хүсэхгүй ээ!
 Харин
 Авсан цалингаа бариад хурдлан, гэрлүүгээ яарсан аавтай
 Авсан дүнгээ аав ээждээ үзүүлэхийг хүссэн үрстэй
 Хийсэн хоолоо ханьдаа хурдхан амтлуулахыг хүсдэг ээжтэй
 Хорвоо дээрх хамгийн жаргалтай амьдралыг би хүсдэг
 Юуны төлөө амьдарч байна вэ? гэхэд
 Юунд ч эргэлзэлгүй гэр бүлийнхээ төлөө
 Юу ч болсон тэднийхээ л төлөө гэж
 Юунаас ч айлгүй, хариулахыг хүсдэг!

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ТЭРГҮҮН БАЙР

Өмнөговь аймгийн Даланзадгад сум, Улсын Тэргүүний “Эрдмийн гэгээ”
ЕБ-ын сургуулийн 10^т ангийн сурагч Б.Цогзол

ШҮЛГИЙН ТӨРӨЛ

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ

Ганхан хөвөлзөх үүлэн дээрээ арван сар зүүрмэглүүлж
Гайхамшигт бүхний охийг хэвлийнхээ ариунаар мэдрүүлж
Голын эхээс тасрах горхи намайг төрүүлэхээр
Гоо марал ижий минь зовлонгийн сайхныг хүртсэн

Бүүр түүрхэн нээгдэх нууцхан диваажингаас
Бүгээн морь хөлөглөн ирэхүйн цагт
Бүлээн амьсгалаар гурвантай нэрийг минь шивнэж
Бөртэ чоно аав минь хайрын мишээлээр гэрэлтсэн

Цас яран дэлгэрэх Чүлчүүбал адил гайхам
Цаг хугацааны үргэжлэл хөврөөнд хөтлөгдж
Цагаан сүү царцашгүй сэтгэл өвлөн
Цагцгай болон та хоёроороо жигүүрлэсэн

Хамгийн сайхан бүхнийг нэгэн үзүүрт сэтгэлдээ сүлж
Хамтдаа зовлонг нулимсаа асган бүхнийг туулах
Халуун гэхэд нарнаас ч халуунаар нэгнээ бүлээсгэх
Хайрыг би гэр бүлдээ хүсдэг.

Араатан хүртэл үрээ хамгаалах орчлонд
Аав нь хүүгээ зэрэмдэглэхийг үзээд
Архины аагинд дэврүүлэхгүй гэсэндээ
Алаг зүрхэндээ би залбирч хонодог
Элбэрэл түгээх эх нь атлаа
Эмзэгхэн үрээ занчихыг үзээд
Ээж минь битгий ийм болоосой гэж
Энгүй бурхны өмнө би залбирч хонодог.

Сэргүү дагасан хүйтэн орчлонд хүүхэд бид
Сэтгэлийн сайхнаар дэлгэрдэг цэцэг болохоороо
Гэгээн амгаланг цацарч яваасай гэж
Гэр бүлээсээ үүнийг л хүсдэг

Мөнхөд хамт амьдрах ч биш
Мөчидхөн амьдралдаа сайхан явъя
Мөрөн дээр чинь тоглох нас болохоор
Мөрөөдөл бүхэнтэй минь хамт байгаач аав ээж ээ!

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ДЭД БАЙР

Завхан аймаг, Түдэвтэй сум, ЕБС-ын 12⁶ ангийн сурагч Н.Пүрэв-Очир



ШУЛГИЙН ТӨРӨЛ

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ

Эсгийгээр үнэг урлаж өсгөсөн
Эцгийнхээ согтуу байхыг хармааргүй байна
Элгэндээ тэвэрч уургаа шимүүлж өсгөсөн
Ээжийнхээ өнчин нулимсыг үзмээргүй байна
Ээж аавынхаа салалтаас болж
Энхрий үрсийг хохиромооргүй байна
Элбэрэлт хайр нь үгүйгээс болж
Эмзэгхэн сэтгэлийг өнчруулмээргүй байна

Үр нь болж төрчхөөд
Үзэл бодол нийлэхгүй байна .
Үндэс мөчир шиг нь нахиалчихаад
Үнэнийг олж мэдэхгүй байна.

Гар утасны хэрэглээ хязгаарлачихаад
Гарамгай сайн сурахыг яаж хүснэ вэ?
Ганц удаа харах интернетийн мэдээ
Гагцхүү мэдлэг болж чаддаг юм, надад

Гадуур гарч найз нөхөдтэйгөө уулзахыг хориглоочоод
Гар барин нийтэч байхыг яаж тушаана вэ?
Найз нөхөд гэдэг чинь миний хувьд
Нийтэч, нээлттэй байлгаж чаддаг зүйл юм.

Хонгор охиных нь та хоёртойгоо хамт байх хугацаа
Хором секундээр хязгаарлагджээ Аав аа Ээж ээ
Хамт байх цаг гаргаач Аав аа Ээж ээ
Халамцуу бол битгий ирээч Аав аа Ээж ээ
Харанхуй шөнөөр битгий ганцаардуулаач Аав аа Ээж ээ
Хар салхи шиг битгий шуураач Аав аа Ээж ээ

Цалин мөнгө чинь хоолондоо хүрэхгүй байхад
Цадах биш хар усаар яах нь вэ? Аав аа Ээж ээ
Цаглашгүй ихээр аз жаргалтай байж чадахгүй ч
Цаг нь болтол ядаж битгий зовоогоо Аав аа Ээж ээ

Тиймээ би үүнийг л хүсдэг
Тэргүүн болсон аавынхаа
Тэнүүн хайрыг л хүсдэг
Тэнгэр шиг ачлалт ээжийнхээ
Тэнэгэр сэтгэлийг л хүсдэг

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ДЭД БАЙР

Орхон аймаг, Баян Өндөр сум, ЕБС 2-р сургуулийн 10^т ангийн сурагч
Э. Түмэнхүслэн

ШҮЛГИЙН ТӨРӨЛ

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ

Буцааж болдогтүй цаг хугацаанаас зөрж алхахгүй тулд
 Буянтай буурал ээжийгээ ачлаж тэтгэхийн тулд
 Буруу хүмүүстэй нийлж бүдэрч сөгдөж унахгүйн тулд
 Буурал сайхан хорвоодоо энх тунх амьдрахын тулд

Би гэр бүлдээ эрүүл энхийг хүсдэг

Битүүхэндээ түүнийгээ биелүүлэхийг хичээдэг

Аадрын үүл шиг барайж, агсаж сагсаж явахгүйн тулд
 Амгалан нойрсох дүүгээ айлгаж цочоож сэрээхгүйн тулд
 Атаат хүмүүстэй нийлж амьдралд хөл алдахгүйн тулд
 Алаг эрээн хорвоодоо амгалан тайван амьдрахын тулд

Би гэр бүлийнхнийгээ хорт зуршлаас хол байлгахыг
 хүсдэг

Битүүхэндээ түүнийгээ биелүүлэхийг хичээдэг

Нартын амьдралаас тусгаарлагдаж насаа элээхгүйн тулд
 Наастай өндөр аавынхаа санааг чилээлгэж суулгахгүйн тулд
 Найрсаг тусч хүмүүстэй мөр зэрэгцэн амьдрахын тулд
 Намираа хурын дусалтай наадан цэнгэж тоглохын тулд

Би гэр бүлдээ аз жаргалыг хүсдэг

Битүүхэндээ түүнийгээ биелүүлэхийг хичээдэг

Адармаатай амьдралд алдаж онож явахгүйн тулд
 Аавын гэрийн голомтыг тасалж зүдэрч гутаахгүйн тулд
 Алаг үрс бид өнчирч шаналж зовохгүйн тулд
 Агаар цэнгэг Монголдоо инээж баясаж амьдрахын тулд

Би гэр бүлээ элэг бүтэн байлгахын хүсдэг

Битүүхэндээ Монголын минь бүх гэр бүл ийм байгаасай
 гэж хүсдэг

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
 ГУТГААР БАЙР

Хөвсгөл аймаг, Цэцэрлэг сум, ЕБС-ийн 12^а ангийн сурагч
 Э.Намхайзорж



ШУЛГИЙН ТӨРӨЛ

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ

Гэр бүлдээ би эд баялаг, эрх мэдлийг хүсдэггүй

Гэр бүлдээ би эрүүл энх амьдралыг хүсдэг

Гэр бүлдээ би гуниг гутрал зовлонг хүсдэггүй

Гэр бүлдээ би элэг бүтэн амьдралыг хүсдэг

Аз жаргал хайрыг хүсдэг

ААВАА би

Амар жимэр амьдралыг хүсдэг

Хосгүй сайхан сэтгэлийн хүсдэг

Хайрхан уул мэт хийморийг хүсдэг

Баатар мэт бай гэж шаардахгүй

Барлаг мэт бай гэж хүсэхгүй

ААВАА би

Бурхан мэт бай гэж шаардахгүй

Боол мэт бай гэж сэтгэхгүй

Энгүй сайхан жаргалыг хүсдэг

ЭЭЖДЭЭ би

Энх тунх амьдралыг хүсдэг

Энэрэнгүй уяхан сэтгэлийн хүсдэг

Энэ хорвоогийн сайхныг хүсдэг

Хатан мэт бай гэж шаардахгүй

Харц мэт бай гэж хүсэхгүй

ЭЭЖДЭЭ би

Хайрхан мэт бай гэж сэтгэхгүй

Хатагтай мэт бай гэж шахамдуулахгүй

Эрүүл саруул амьдралыг хүсдэг

БИ өөртөө

Эрдэм мэргэн оюуныг хүсдэг

Энгүй сайхан сэтгэлийг хүсдэг

Эх орны хүү байхыг хүсдэг

Гэр бүлдээ би эд баялаг, эрх мэдлийг хүсдэггүй

Гэр бүлдээ би эрүүл энх амьдралыг хүсдэг

Гэр бүлдээ би гуниг гутрал зовлонг хүсдэггүй

Гэр бүлдээ би элэг бүтэн амьдралыг хүсдэг

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ГУТГААР БАЙР

Сэлэнгэ аймаг, Шаамар сум, Дулаахан ЕБС-ийн 10^т ангиин сурагч

Н.Мишээл

ШҮЛГИЙН ТӨРӨЛ

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ

Болдогсон бол аавынхаа суран бүсийг нуучих сан
Болдогсон бол аавынхаа нүцгэн гарыг хүлчих сэн

Хаалганы хонх дугарахад
Дүү нар минь тал тал тийш
Дарсанд согтсон аав хүүхдүүдээ дуудна
Нааш ир...

Дэндүү балчирхан тэднийг
Дарамтална чинээ хэн мэдэх вэ?

Дэргэдээ байгаа жаргалыг
Дорд үзнэ чинээ хэн мэдэх вэ?

Гарынх нь шүүс болохыг мэдсэн бол
Гарцаагүй тань дээр лав ирэхгүйсэн

Гэдсэн дотроо байхдаа гарахыг их хүссэн дээ
Гадаад ертөнц ийм гэдгийг
Гагцхүү сая л би ухаарлаа

Болдогсон бол гэртээ аз жаргалтай амьдрах юмсан
Болдогсон бол гэртээ амар тайван байх сан

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ГУТГААР БАЙР

УБ хот, ЧД, ЕБС-ийн 50-р сургуулийн 12^т ангийн сурагч П.Мөнхзаяа



ШУЛГИЙН ТӨРӨЛ

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ

Халамж хайр, инээд хөөр булаг мэт ундардаг
Хамтдаа байгаа мөч бүр нь гайхалтай дурсамж болдог
Сайхан сэтгэл ухаалаг зан далай мэт мэлтийдэг
Санаа амар, тайван амгалан, түвшин жаргалтай байдаг

Би гэр бүлдээ үүнийг л хүсдэг

Ачлалт аав ээжээ тэнгэр мэт хүндэлдэг
Алаг хөөрхөн үрсээ эрдэнэ мэт нандигнадаг
Хань ижлээ ургамал цэцэг мэт арчилдаг
Хэн хэнээ хаан хатан мэт хүндэлдэг

Би гэр бүлдээ үүнийг л хүсдэг

Өвдэж зовсон үед нь эмч мэт асардаг
Өлсөж ядарсан үед асрагч мэт халамжилдаг
Андуу эндүү алдааг нь бурхан мэт уучилдаг
Алдаж онох тоолонд нь багш мэт ухааруулдаг

Би гэр бүлдээ үүнийг л хүсдэг

Хайр энэрэл, аз жаргал гэр бүлээсээ мэдрэх нь
Хорвоод хүн болсны хамгийн сайхан бэлэг
Элэг бүтэн, сэтгэл дүүрэн гэр бүлийг бүтээх нь
Энэ дэлхийд мэндэлсний хамгийн агуу үйлс

Би гэр бүлдээ үүнийг л хүсдэг

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ТУСГАЙ БАЙР

Хэнтий аймаг, “Тэмүүжин” ЕБ-ын сургуулийн 11^т ангиин сурагч
Н.Бүжинлхам

ШҮЛГИЙН ТӨРӨЛ



БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ

БИ ҮҮНИЙГ ХҮСНЭ

Нутгийн цэнхэр салхia ногтолж үлдэх юмсан
Нугийн гоёмсог цэцэгсээ тушаад өвөлжүүлэх юмсан
Нуруу алаг ангирыг нь нуугаад байлгах юмсан

Би дэлхий гэртээ үүнийг л хүснэ
Зүүдний мянган оддыг дэргэдээ уячхаад
Зүүдлээд сэргэг ижийгээ хөтлөөд өтлөх юмсан

Би үүнийг л гэр бүлдээ хүснэ
Газрын сайраас хормойлсон түмэн чuluудын тоогоор
Ганган хадаг намируулсан хийморийн сүлдтэй овоондоо
Яргуй дэлгэрэх хавраар аз жаргалыг урина
Ямархан их хайр хаана л байна түүнийг өгөөч гэж би хүснэ
Тиймээ би зорилго ихтэй Монголын хүү
Зон олон нутаг усаа миний гэр хэмээн боддог цэс
ихтэй хүний үр

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ТУСГАЙ БАЙР

УБ хот, СХД, ЕБС-ийн 62-р сургууль 11^к ангийн сурагч Б.Билгүүн



ЗОХИОН БИЧЛЭГИЙН ТӨРӨЛ

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ

Би гэр бүлдээ аз жаргалыг л хүсдэг. Би гэртээ аз жаргал хэмээх үр суулгахыг хүсдэг. Учир нь аз жаргал хэмээх үрнээс хайр, халамж, энэрэнгүй сэтгэл гэдэг үндсээрээ холбоотой хос модод ургадаг юм. Тэрхүү хос моддоос эв нэгдэл, сайхан сэтгэл хэмээх үзэсгэлэнтэй өнгөлөг цэцэгс дэлгэрдэг билээ.

Гэхдээ би зөвхөн гэр бүлдээ ч биш хүн болгонд аз жаргал хэмээх үр тарааж өгөхийг хүсдэг. Энэ үрийг өөртөө хадгалах биш бусадтай хуваалцах хэрэгтэй. Зарим хүмүүс аз жаргал гэдэг үрийг яж тарихаа мэддэггүй. Түүнийг инээмсэглэл гэдэг хөрсөнд суулгаж, үнэнч сэтгэлээр бордон өдөр бүр хайраар услах хэрэгтэй гэж би боддог.

Би гэр бүлдээ аз жаргалыг л хүсдэг. Айл болгоны гадаа аз жаргал хэмээх үрнээс ургасан хос модод цэцэглэж байхыг харах л хамгийн сайхан мэдрэмж. Гэхдээ би газар доорх баялгаас болж хайр халамж, энэрэнгүй сэтгэл гэх хос моддыг хугалж, гэмтээж, тайрахыг харж чадахгүй. Аз жаргалгүй хүн хэзээ ч сайхан амьдарч чадахгүй. Тийм болохоор аз жаргал ирвэл хэзээ ч алдаж болохгүй гэж хүмүүс ярьдаг байх. Аз жаргал хэмээх үр үүрд айл болгоны гадаа нахиалж байгаасай.

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ТЭРГҮҮН БАЙР

Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, ЕБС-ын 1-р сургуулийн 7^т ангийн
сурагч А.Эмүүлэн

ЗОХИОН БИЧЛЭГИЙН ТӨРӨЛ



БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ

Гэр бүл гэж юу вэ? Миний бодлоор гэр бүлд гэдэг нь халуун дулаан уур амьсгал, эзрэг сайхан сэтгэл, ширээ тойрон суугаад хамтдаа хооллох аз жаргал гэж би боддог. Энэ дэлхийн сая сая гэр бүлийн дотроос миний гэр бүл хамгийн сайхан нь юм. Би үүнийгээ шилж аваагүй, бурхан надад хайрласан заяа юм. Нэгэн өдөр манай гэрийнхэн гэртээ суугаад цайгаа ууж байтал нэг үл таних хүн орж ирээд “Танайх аймгийн аварга малчин боллоо” гэж билээ.

Бид юуг ч хийсэн том жижиг хамаагүй зүтгэдэг учир хамтдаа бүхнийг чадна гэдгийг надад энэ үйл явдал хамгийн ихээр мэдрүүлсэн юм. Тиймээс би энэ дэлхийн бүх гэр бүлийг хүсэл зорилгынхoo төлөө тэмүүлж буй од мэт байгаасай гэж боддог.

Та гэр бүлээсээ юуг хүсдэг вэ? гэж асууваас би гэр бүлээсээ аяга будаа л хүсдэг. Гэхдээ энэ дэлхийн хамгийн сайхан аз жаргалыг шингээсэн халуун будааг л би хүснэ. Тэр будаагаа хамтдаа идэж инээлдэн баяр хөөртэй байхыг л хүснэ. Энэ бол миний гэр бүлээ гэсэн ганцхан хүслэн минь билээ.

Б.Баяржавхлан яруу найрагчийн “зохиол” шүлгээс ишлэхэд...

...Энэ үүл

Тээр дээр

Тэр үүл

Энэ хүсэлд

Тэд адилхан юм”... гэж зохиосон байдаг.

Хүсэл ямар ч хол байсан тухайн хүний сэтгэл нь ойр бол тэд адилхан гэсэн үг. Тийм учраас миний хүсэл биелнэ гэдэгт би бат итгэж байна. Гэр бүл нь хүсэл тэмүүлэл, аз жаргал, сайхан сэтгэлээс л тогтдог юм байна. Бодолд минь цэцэг болж ургажээ гэр бүл минь. Хайртай шүү та нартаа.

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ДЭД БАЙР

Завхан аймаг, Идэр сум, ЕБС-ын 8^б ангийн сургач М.Бүрэнтэгш



ЗОХИОН БИЧЛЭГИЙН ТӨРӨЛ

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ

Манай гэр бүлд тулгын гурван чулуу мэт бие биеэ түшсэн эв найрамдалтай хоёр охин нэг хөвгүүн бий. Харин тэр гурван чулуун дээр байрлах тулга бол бидний сайн аав халамжит хань болох гэрийн эзэн юм. Тэрхүү тулган дээр байх тогоо нь энэрэлт ээж, элбэрэлт гэргий болох гэрийн эзэгтэй. Харин тэр тогоон дотор буцлах цай нь бидний амьдрал. Хэрвээ тулгын гурван чулуунаас нэг нь үгүй бол тулга хазайна, тогоо ч дагаад хазайна. Хазгай тогоондох цай халгин асгаж, дусал дусалаар урсан одно.

Бид хамтдаа байвал амьдрал минь буцалж бусдад амттай сайхан цай болно. Хэрэв биднээс хэн нэг нь үгүй бол гүйцэд сүлэгдээгүй халуун сав дүүргэж чадахааргүй тийм л муу цай болно. Харин тэр цай амтлан уух эзэд нь бидний ахан дүүс хамаатан садан. Цайны ааг амтагдаж, сүлэрсэн сайхан болбол хүн бүр магтан сайшааж дахин дахин эндээс ундаалах болно. Хэрэв тулгын гурван чулуу үгүй бол тулга, тогоо үгүй. Тулга үгүй бол чулуу, тогоо үгүй. Тогоо үгүй бол амьдрал буцлах үндэс байхгүй. Иймээс гэрийн эзэгтэй ээжүүд амьдрал хэмээх халуун цайг сүлэхэд маш том хувь нэмэр оруулдаг юм шүү. Бүгдээрээ элэг бүтэн, энх мэнд байж энэ амьдралынхаа турш бусдад сайшаагдсан сайн цай сүлэхийг хичээцгээе.

Би гэр бүлдээ үүнийг л хүсдэг.

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ДЭД БАЙР

Дорноговь аймаг, Сайншанд сум, ЕБС-ын 2-р сургуулийн 7^а ангийн
сурагч Г.Болормаа

ЗОХИОН БИЧЛЭГИЙН ТӨРӨЛ

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ

Хүний амьдрал солонгын долоон өнгөтэй адил. Байнга хувирдаг хувирамтгай. Өнөөдөр нэг бодоод маргааш нь дахиад болиод өөр юм боддог биз дээ. Би гэр бүлдээ сайн сайхан, аз жаргалыг хүсдэг. Солонго ч мөн адил хүмүүст аз жаргал, баяр баясгалан бэлэглэхээр татдаг гэж би боддог. Гэр бүл аз жаргалтай байна гэдэг ганц хүн хичээх биш бүх хүн чин сэтгэлээсээ хичээхийг хэлнэ. Бид хүнд хэцүү юмаа дотроо л хадгалаад байдаг. Харин тэгэх биш бусдадаа дэлгэж ярилцаж сэтгэл доторхоо уудалж байвал гэр бүл нь тэр хүнд илүү их итгэл хүлээлгэнэ.

Гэхдээ бороо орсны дараа солонго татдаг шиг хүн ямар нэгэн шалтгаангүй зүйл хийдэггүй гэж хэлж болно. Манай гэр бүл яг солонгын өөр өөр өнгө шиг нэр, бодол, хийж байгаа үйлдэл бүгд өөр. Аав маань тайван цэнхэр өнгөнөөс ширүүн хурц хөх өнгө рүү шилждэг хувирамтгай хүн. Ээж маань улбар шар өнгө шиг хоёр зүйлийг зэрэг хийж чаддаг. Ахдаа би ногоон өнгө өгнө. Би ахаасаа яг газар шиг хэзээ ч орхихгүй нөмөр нөөлгийг олж авдаг. Шар өнгө бол миний эгч юм. Энэ өнгө нь тайван байдлыг илэрхийлдэг. Харин хоёр дүүдээ ягаан өнгө өгнө. Өхөөрдөм хөөрхөн болохоор энэ өнгө үргэлж зохино.

Эсрэг тэсрэг энэ олон орчинг гэр дүүрэн инээд, баяр баясгалан нэгтгэн гэр бүлдээ юу хүсдэгийг ойлгуулна. Энэ хорвоо дээр хамгийн хүчтэй нь эсвэл өндөр боловсролтой нь шалгарч үлддэггүй. Харин бусдыг хайрлан тэдний төлөө чин сэтгэлээсээ ханддаг нь шалгарч үлддэг.

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ГУТГААР БАЙР

Багануур дүүрэг, Боловсрол Цогцолбор Сургууль 6^т ангийн сурагч
Д.Дэжилгарав



ЗОХИОН БИЧЛЭГИЙН ТӨРӨЛ

"ЗҮРХНИЙ БИЧЭЭС - БИ САЙН ААВ БОЛНО"

Миний ээж аав 2 чухам яагаад салсан нь надад оньсого таавар мэтээ. Харин миний ээж гайхалтай эх хүн шүү. Намайг өдий болтол өсгөж тэтгэж, усалж тордож ургуулсаар л яваа.

Би аавыгаа буруутай гэж бодлоггүй. Миний ээж аав хоёр амьдралын хатуу хөтүүг тэсэж чадалгүй хагацсан гэж ойлгодог. Үеийн хүүхдүүд аавтайгаа эрхлэн тоглож хамт зугаалж явахыг хараад би атаархдаг. Атаархаж байгаагаа хараад би өөрийгөө өөдгүй амьтан гэж бас заримдаа боддог гээч.

Гэхдээ би төрсөн биш ч гэсэн өсгөж дэмжиж өдий болгосон сайхан аавтай. Бүүр багадаа ээж минь намайг эцгийн нөмрөөр дутаахгүй гэсэндээ ч юумуу хоёрдах аавтай болгож өгсөн. Миний хоёрдах аав намайг хайлрадаг. Гэхдээ л би уйлсан уйтгарласан гомдсон үедээ надад аав минь алга гэж багтран боддог.

Гэр бүл салалт гэдэг аймшигт үгийг үгсийн сангаас авч хаяхыг хүсэж мөрөөдөж байна. Би энэ явдлын золиос болсондоо харамсан гунидаг. Аав ээж хоёроо дахин хамт амьдруулж аз жаргалд умбахыг хүсэж л явдаг. Над шиг гунигтай явдаг хүүхэд олон битгий байгаасай. Тиймээс би сайн аав л болно.

Хүмүүсээ амьддаа бие биенээ хайлра.
Өглөөнөөс орой болтол хэрэлдэхгүй
Өвлийн цас шиг хүйтэн үгээр хайрахгүй
Өндсийн чинээ үрсээ өнчрүүлэхгүй
Өнө мөнхөд аз жаргалтай амьдарна би.

БИ САЙН ААВ БОЛНОО.

**БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСНЭ 2017 УРАЛДААНЫ
ГУТГААР БАЙР**

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, ЕБС 1-р сургууль, 6^т анги
Батцэцэг овогтой Амарбаясталан

ЗОХИОН БИЧЛЭГИЙН ТӨРӨЛ

Эрээнтэй бараантай хүний орчлонд ээж авынхаа үр нь болж хайр хэмээх халуун өлгийгөөр өлгийдүүлэн өсч торnisон хүү нь би. Хүний хүүхдээс дутаахгүй өсгөх гэж хуруу хумсаа хугалж, халуунд халж, хүйтэнд хөрч намайг бий болгосон аав ээж минь надад хамгаас үнэтэй. Дардан биш замыг дурдан болгох гэж, давс шиг үгсийг чихэр шиг болгох гэж, зовлонгийн харгуйг, жаргалын яргуй болгож дэлбээлүүлсэн. Тэдэндээ би хязгааргүй их баярладаг.

Нийгмийн толь болсон монголын олон гэр бүлийн нэг нь манайх. Бусдаас илүү гарч гийгүүлэхгүй, бүр дордож сөхрөхгүй хоёр идэж хоосон хонохгүй, болж бүтнэ гэсэн итгэлээр жигүүрлэсэн эгэл нэгэн айл. Өдөр бүр az жаргалтай инээдээр цалгиж байдаггүй ч гэлээ хааяа санаадаа элгээ хөштөл инээх сайхан дурсамж бас цөнгүй.

Би бодохдоо гэр бүлийг биесээ сонсдог, харилцан итгэлцдэг, хайраар гэрэлтдэг ертөнц гэж төсөөлдөг. Харин тэр ертөнцийн az жаргалын үр нь хүүхэд. Харамсалтай нь сүүлийн үеийн хүүхдүүд эцэг эхийнхээ хайр халамжийг эс эдлэн, элэг зүрхийг нь сэмлэж суух нь олонтаа. Би мөн л адил тэдний нэг. Эгч дүү бид гурвын төлөө өөрсдийгөө умартан, хуучин хувцсаа очиоён жил өмсөж, хар бор ажил хамаагүй хийж, өвдөжзовлоо ч ганц ёо гэлгүй үр хүүхдүүд минь гэж ухаангүй гүйдэг хөөрхий аав ээжтэйгээ таарахдаа ичдэг. Одоо бодох нээ аав ээжийнхээ хувцаснаас биш өөрийнхөө өөдгүй зангаас л ичих байж.

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ

Бас ээжийнхээ хийсэн хоолыг голдог. Зарим хүүхдүүд хоолгүй, харин зарим нь ээжгүй байгаа шүү дээ.

Би одооноос хичээн сурч том болоод мундаг дуучин болохыг хүсдэг. Тэгээд тогтолгоо хийгээд олсон мөнгөөрөө ээжийнхээ бөөрийг, эгчийнхээ зүрхийг эмчлүүлнэ. Гэрийнхэн маань байнга инээмсэглэж явбал сайхан.

Би баян тансаг амьдралыг хүсэхгүй
Бие биесээ мартаад мөнгө
эрэлхийлдэг болчихно

Би солонгын өнгөнд хууртажгүй
Битүүхэн гансраад алга болчихно
Би алт эрдэнэсийг сонирхохгүй
Билиг оюун сэтгэлийн хажууд тэр хямдхан

Би бэлэн амьдрал гүйж залбирахгүй
Бие сэтгэлээ зориулж олоогүй бол
тэр очуухэн

Би инээд цалгиасан амьдралыг хүснэ
Бяцхан цээжнээсээ сүслэж хүснэ
Би эрүүл жаргалтай амьдралыг хүснэ

Биелүүлж өгөхийг бурхнаас хүснэ
Би халуун дулаан хайрыг хүснэ
Бүдэрч хуучрахгүй улам бадраахыг хүснэ

Би гэр бүлдээ үүнийг л хүсдэг
Биелэлээ олох жаргал минь
байгаасай гэж хүсдэг

Тэнэг мунхагч бай, өөдгүй бохир ааштай ч бай, халтар царайласан заваан ч бай, худал ч, хулгай ч бай түүнийг үл тоон хэзээ ч сэтгэлээ хувиргахгүйгээр намайг хайрлах аав ээж, гэр бүлийнхэндээ би хайртай.

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ГУТГААР БАЙР

Архангай аймаг, Эрдэнэбулган сум, Спортын төрөлжсөн сургалттай ЕБС-ын 6^т ангийн сурагч М.Баярмагнай



ЗОХИОН БИЧЛЭГИЙН ТӨРӨЛ

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ

Би гэр бүлийнхэнтэйгээ хамт цаг мөч бүрийг аз жаргалаар дүүрэн өнгөрөөхийг хүсэж байна. Мөн аз жаргал байгаа газар бусад бүх зүйл өөрөө ирэх мэт санагддаг.

Миний гэр бүл миний инээмсэглэх шалтгаан...

Миний гэр бүл миний баясах шалтгаан...

Хүн хүндээ хэрэгтэй гэдэг. Аз жаргал ч мөн адил. Надад гэр бүлдээ аз жаргалыг хүсэх мянга мянган шалтгаан байна. Анх энэхүү замбуулинд төрсөн цагаасаа эхлээд л тэднийгээ харж мишээж, баярласан... Гэр бүлийнхэн маань бидний анхны хайр биш гэж үү? Тэд бол анхдагч шүү дээ! Тэдэнтэй минь холбоотой сайхан дурсамжууд барагдашгүй их. Тиймээс цаашдаа ч улам их аз жаргалтай байхыг хүсэж байна. Эд бол ердөө л нэгхэн хэсэг нь.... Надтай адил хүүхэд бүр гэр бүлдээ аз жаргалыг хамгийн ихээр хүсдэг байх гэж бодож байна.

Гэвч зарим хүүхдүүд эзгийнхээ дулаан, түшигтэй нөмөр, эхийнхээ цагаан сүүг ч амсаж чадахгүй байна. Гэр бүлд хүүхэд л хамгийн ихээр баяр баяслыг авчирдаг хэмээн ярьцаадаг. Гэхдээ тэнгэрээс бидэнд өгсөн агуу их бэлэг биш гэж үү! Магадгүй тэд орой унтах бүртээ мэлмэрэн уйлж, эцэг эхээ санан өгүүлдэг байх. Яагаад бяцхан үрсдээ хорвоогийн сайхныг бус, мууг амсуулна вэ? Тиймээс л би энэ дэлхийн бүх гэр бүл аз жаргалтай элэг бүтэн амьдраасай гэж хүсэж байна.

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ТУСГАЙ БАЙР

Чингэлтэй дүүрэг, ЕБ-ын 50-р сургуулийн 7^т ангийн сурагч Г.Эгшиглэн

ЗОХИОН БИЧЛЭГИЙН ТӨРӨЛ

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ

Нуурын ус чимсэн нугас шиг ээж

Нуга толгодоо хамгаалах ноён нуруут аав

Алдар нэрийг бүтээх авьяаслаг сайхан ах

Аз жаргалыг түгээх алдрай бяцхан дүү

Амьдралыг холбогч гүүр алагхан жаахан бид тавуулаа амьдардаг.

Гарын таван хурууг бүтээх нь нэг л утга учиртай.

Манайх үнэд хүрэхээр том тавилгагүй, үзэмж нэмхээр чамин эд зүйлгүй ч гэсэн амжилт гэгч асар томоньсыг аз жаргал хайрын хүчээр олдог. Ажил гэсээр ядарч сульдсан ээж маань ажлаасаа орж ирэхэд аяга дүүрэн халуун хоолоо хийгээд хүлээж авдаг аавын хайр сайхан. Энэ л гэхэд амьдралын түмэн нугачаанаас хородж, аз жаргалыг бүтээж амжилтыг илгээнэ.

Гэр бүлийн хамгийн чухал зүйл нь халуун дулаан уур амьсгал байдаг. Мөн “зовлонгийн түргэн нь” дээр гэдэг үгийг ээж минь байнга хэлж өөрөө үлгэр дуурайдал үзүүлдэг. Аянга цахилгаан цахиж байсан ч бид хэзээ ч ганхахгүй. Учир нь гарын таван хурууныхаа байрлалыг зөв эзэмшсэн юм. Та нарт л хэлэхэд “та ямар үр тарина, тийм л ургацыг хурааж авах” учраас эхэллээ зөв тавих хэрэгтэй шүү. Эцэст нь Гантиг чулуу шиг чамин агаад хатуу орчлонд

Газар тэнгэрийн зааг хаяанд

Ганц ч гэсэн айл зовлонгүй байг

Яахав дээ тэд зовлон үүрсэн байж магад

Харин тэднээс юм бүү хүс

Хэрэг гарвал сэтгэлийг л хүс

Та бүхэн аз жаргалыг мөрөөдвөл хайрыг мөрөөд, хайрыг мөрөөдвөл халуун дулаан ам бүлийг мөрөөдөөрэй.

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ТУСГАЙ БАЙР

Увс аймаг, Тариалан сум, ЕБС-ын 7^а ангийн сурагч Т.Бат-эрдэнэ

“ЗУРГИЙН
ТӨРӨЛ”

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ



“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ТЭРГҮҮН БАЙР

СХД, ЕБС-ын 106-р сургууль 4^т ангийн сурагч Б.Ариун-Эрдэнэ

ЗУРГИЙН ТӨРӨЛ

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ



“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ДЭД БАЙР

Завхан аймаг, Цагаанхайрхан сум, ЕБС-ын Заангийн сургач Т.Батчимэг

“ЗУРГИЙН
ТӨРӨЛ”

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ



“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ДЭД БАЙР

УБ хот СБД, ЕБС-ын 16-р сургууль 3^д ангийн сурагч С.Оюун-Эрдэнэ

ЗУРГИЙН
ТӨРӨЛ

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ



“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ГУТГААР БАЙР

Багахангай дүүрэг, Хангай цогцолбор сургууль 3^ө ангийн сурагч Б.Буян-Эрдэнэ



“ЗУРГИЙН
ТӨРӨЛ”



БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ



“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ГУТГААР БАЙР

Баян-Өлгий аймаг, ЕБС-ын 1-р сургууль 3^д ангийн сурагч А.Айзухра

ЗУРГИЙН ТӨРӨЛ

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ



“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ГУТГААР БАЙР

Төв аймаг, Зуун мод сум, Хүмүүн цогцолбор сургуулийн 4^т ангийн сурагч У.Маргад



**ЗУРГИЙН
ТӨРӨЛ**

БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ



“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ТУСГАЙ БАЙР

УБ хот, ЧД 50-р сургууль Зд анти С.Чингүүн

ЗУРГИЙН
ТӨРӨЛ



БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ



"Миний дуу хурдан гарасай"
Б.Ирмүүн, эзгэлж б.настай,
Хөтөнчийн 3-р хорооны балтагч УЧЫН

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ-2017” УРАЛДААНЫ
ТУСГАЙ БАЙР

УБ хот, БЗД 52-р цэцэрлэг бэлтгэл 1^к бүлэг Б.Ирмүүн



“ХҮҮХДҮҮДИЙН БҮТЭЭЛЭЭС ТҮҮСӨН ШИГТГЭЭ”

1. Ээжээ! Хүүхдүүд ээжтэйгээ хөтөлөлцөөд явахад би атаархдаг. ...Миний дэргэд намайг хайлаж, бусдын адил аз жаргалтай, инээд хөөртэй, энэл тэнгэр шиг уудам амьдрахыг хүсч байна. (Дундговь аймаг 8^а ангийн сурагч М. Б 14 нас)
2. Ээж минь л намайг ойлгоно. Ээжтэйгээ нэг цаг ч гэсэн ярилцвал цаашид амьдрахад илүү амар тайван болно гэж бодсон миний өчүүхэн төсөөлөл. (Дорноговь, 7^а ангийн сурагч Б.У 13 нас)
3. Хэн нэгэн надаас хамгийн сайхан амьдрал юу вэ гэж асуувал: “Элэг бүтэн, эрүүл энх, эв найрамдалтай гэр булийг л хамгийн сайхан амьдрал” гэж хэлнэ. (Өвөр хангай, 7^а ангийн сурагч М. П)
4. Та минь Эцэг хүний хайр хalamж, нөмөр нөөлгөөр охин үрсээ хайлаж, сайн нөхрийн өмөг түшгээр ээжийг минь хайлаж, эр хүний ноён нуруугаар голомтоо түшин тулж, бид хамтдаа энх амгалан аз жаргалтай амьрана гэдэгт итгэх ёстой. (Хөвсгөл аймаг, 9^в анги сурагч А. Е 14 нас)
5. Манай гэр бүл гоё үнэтэй тавилга, гоё хувцас өмсөж явахыг жаргал гэж бодлогүй, харин өөр өөрийнхөөрөө байж, инээж хөгжилдэж байх нь манай гэр булийн жаргал. (Увс аймаг, 7^а анги сурагч Г. Б 12 нас)
6. Аав, ээжийгээ үнсэх болов уу? гэж удаан ширтлээ үнссэнгүй, дугарсанчгүй. Өөрийн мэдэлгүй миний нулимс цийлэтгнэж нулимс минь удаанаар бөмбөрлөө. (Завхан аймаг, 5^а анги сурагч Р. Э 10 нас)
7. Аавыгаа архинаас гаргаад, ээжийгээ өвчинөөс салгачихвал бурханаас өөр хүсэх зүйл байхгүй. (СБД 7^в ангийн сурагч Э. Б)
8. Хэдий нүдэнд харагдахгүй ч сэтгэлд мөнхөрсөн нүдэнд биш зүрхэнд харагддаг тийм л амин холбоотой хүмүүсийг гэр бүл гэнэ. (Хэнтий аймаг 7^а ангийн сурагч О. Э)
9. Зүгээр л бороо салхинд нураад унахааргүй байшин, эрүүл саруул халуун дулаан гэр бүлийн уур амьсгал, дутагдаж гачигдаад байхааргүй энгийн амьдрал л хүсдэг. (Дорнод аймаг 8^а ангийн сурагч Б. С)
10. Аав минь гэртээ байхдаа намайг инээлгэж чаддаг, яг л хүүхэлдэйн баатар шиг, харин ээжийн минь гар үргэлж дулаахан бас яг над шиг аавыг минь хараад инээдэг байгаасай гэж хүсдэг. (З-р сургууль 4^а ангийн сурагч Г. Г)
11. Хэдийгээр манайх ядуу ч бие биедээ итгэж, хүндэлж, нэг нэгнээ бэлэг хэмээн хүлээн авч бүх зүйлийг зерэгээр харж амьдардаг. Миний ганц хүсэл бол энэ бүхэн үеийн үед мөнхөд үргэлжлээсэй хэмээн хүсдэг. (Сэлэнгэ аймаг, 8^б ангийн сурагч Г. Д 14 нас)
12. Би баян авьяастай болохыг хүсдэггүй. Харин гэр бүлтэйгээ инээд хөөрөөр цалгиж, баяр баяслыг мэдрэхийг хүсдэг... Аав ах хоёр маань эрүүл болчихвол хөл минь газарт хүрэхгүй нисэх мэт болох байхаа. (Дорнод аймаг ба ангийн сурагч Э. Ц 11нас)
13. Аав ээж дүү нартайгаа халуун ам бүлээрээ гадуур зугаалж бүтэн өдрийг тэдэнтэйгээ хамт аз жаргалтай

ХҮХДҮҮДИЙН БҮТЭЭЛЭЭС ТҮҮСЭН ШИГТГЭЭ

өнгөрүүлэхийг хамгийн их хүсдэг. (7^а ангийн сурагч Р. Г.)

14. Ээж минь надад “Миний охин том болох гэж биш хүн болох гэж яараарай” гэж захидал. Мөн “Нарт хорвоод үр минь чи сайн явбал насан турш баярлуулах их ачлал тэр шүү” гэсэн үгийг үргэлж санаж явдаг. (Сүхбаатар аймаг, 4^а ангийн сурагч Н. А)
15. Би гэр бүлээсээ ганц л зүйлийг хүсдэг. Энэ бол инээмсэглэл. (7^а ангийн сурагч А. Н 13 настай)

Арван сар хэвлэлийд нь амьдарсан болохоор

Ангир уургыг нь залгисан болохоор

Эрднээс үнэтэй ижийтэйгээ

Энх тунх амьдрахыг хүсдэг

(Хөвсгөл аймаг, 11б ангийн сурагч П. П.)

Баян чинээлэг баргил хатуу

Гэр бүлийг би хүсэхгүй

Боломж дүүрэн хайр бялхсан

Гэр бүлийг би эрхэмлэнэ

(Завхан аймаг, 12-р ангийн сурагч Г. А 17нас)

Ханилах биш хагацах гэж нийлсэн юм
гэж үү

Үрсээ өнчрүүлж

Хагацах үзүүлэхийн учир юу вэ

Үүрд мөнх тэр үрс чинь сэмэрч явна
шүү дээ

(Дорноговь аймаг, 11г ангийн сурагч Г.Б 16 нас)

Ээжийн минь хийсэн хоолны дээжийг
зооглоод

Энхрий бяцхан хүүгийнхээ магнайг
үнэрлээч

Өрх гэр чин хоосорчээ ааваа танийг
үгүйлээ биз

Өрхийг нь татаад нулимстай орж ирэх
юм ээж минь

(Баян-Уул 11б Б. Болортуяа 17 нас)

Хундганд үлдэх архинаас илүү

Хүүгийнхээ нулимсийг хямгадаач

Сэтгэл зүрхийг минь мохоож битгий
хатуурхаач

Сэвэлзээд өнгөрөх салхи шиг намайг
битгий орхиоч

16. (Хөвсгөл аймаг, 11а ангийн сурагч А. Т 17 нас)



ХҮҮХДҮҮДИЙН
БҮТЭЭЛЭЭС ГАРСАН
ТОМЧУУДАД
ХҮРГЭХ ҮГС

Зурсан зургаас тухайн хүүхдийн сэтгэл зүйн байдал, гэр бүлийн харилцаа хандлага гэр зэргээр тус хүүхдийг тодорхойлон шинжих боломжтой байдаг. Эдгээр уран зургуудыг харвал хүүхдүүдийн гэр бүлдээ хүсэж буй аз жаргалын тодорхойлолт нь өөр өөр байсныг дор өгүүлье:

- Амар тайван, баяр хөөртэй амьдралыг
- Элэгсэг дотно харилцаатай, элэг бүтэн амьдралыг
- Аавын нөмөр нөөлөг, халамж, түшиг тулгуурыг
- Гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг
- Гэр бүлээрээ хамтдаа тоглож наадан зугаатай цагийг өнгөрөөхийг
- Аав ээжийгээ баяр наадам, амралтын өдрөөр цаг гарган хамт байхыг
- Гэр бүлээрээ хамтдаа аялахыг
- Санхүүгийн гачигдалгүй байхыг
- Элбэг хангалаан байдлыг
- Ажил орлоготой байгаасай
- Эрүүл байгаасай
- Бие биенээ хайрлаасай
- Бусдыг хайрлаасай
- Архи битгий уугаасай
- Хайрлаж халамжлаасай
- Үурладаггүй байгаасай
- Намайг ойлгоосой
- Аав ээж маань надтай харилцаж намайг анхаараасай
- Дуртай зүйлийг минь хамтдаа хийгээсэй
- Эдгээрээс хамгийн олон давтагдсан зүйлс нь: "намайг хайрлаач", "хамтдаа цагийг өнгөрөөгөөч", "хамт аялалаар явъя", "халуун дотно байгаач" гэх зэргээр өөрийн аз жаргалтай гэр бүлийг бий болгоход гэр бүлд нь дутагдаж байгаа хүслээ зурган дээр буулгасан байна.

Би гэр бүлээсээ үүнийг хүсдэг? (шүлэг)

Шүлэг бичих энэхүү уралдаанд маш олон төрлийн шүлэг ирсэн ба насны ангилалын

нутаг, нутгийн маш олон шүлэг ирсэн ч агуулга, илэрхийлж буй санаа, гэр бүлээсээ хүсэх хүсэл нь нэгэн адил нийтлэг байсан. Өөрсдийн амьдралд ирсэн хамгийн том бэлэг, энэ хорвоогийн гэрэл гэгээ болсон үр хүүхдээ үл хайхарч, эд баялаг хөрөнгө мөнгө илүүд үзэж хүүхдүүдээ хэрхэн зовж шаналж байгааг нь ч мэдэхгүй байгаа нь энэхүү хүүхдүүдийн бичсэн шүлэгнээс харагдаж байна.

Хүүхдүүдийн гэр бүлээсээ хүсдэг хүслүүдээс:

- Гэр бүлээсээ халуун дулаан уур амьсгал болон амьд харилцааг хүссэн.
- Гэр бүлийн хайр халамжийг илүүтэй хүссэн.
- Аавыгаа анхаардаг ээжийгээ халамжаар дүүрэн дүү нараа хөгжил хөөртэй, ухаантай байгаасай гэж хүссэн.
- Элэг бүтэн амьдрал энэ хорвоод их чухал гэдгийг хэлсэн.
- Дарамтгүй амар амгалан амьдралыг хүссэн
- Архины хамаарлаас гараасай гэж хүссэн.
- Бас ихэнх шүлэг нь дээр хайр гэж юу вэ? Халамж гэж юу гэдэг вэ? Гэсэн асуултыг шүлэг болгон дээрээ тусгасан.
- Ядуу амьдралаас минь салгаж өгөөч гэж зарим нэг нь хүссэн.
- Хэрүүл тэмцэлгүй амьдралыг хүссэн.
- Хүүхдээ ойлгож гомдоолгүй харилцахыг хүссэн.
- Эзж аавыгаа үүрд мөнх байгаасай гэж хүссэн.
- Аав ээжийнхээ ачийг харуулахыг хүссэн.
- Бие биенээ ойлгож хүндэлдэг байхыг хүссэн.
- Гэр бүлдээ сайн сайханыг хүссэн.
- Эв ээ, инээд хөөрийг хүссэн.
- Хүчирхийлэлгүй амар тайван

ХҮҮХДҮҮДИЙН БҮТЭЭЛЭЭС ГАРСАН ТОМЧУУДАД ХҮРГЭХ ҮГС

- Амьдралыг хүссэн
- Гэр бүлдээ нээлттэй сайхан харилцааг хүссэн.
- Эгэл жирийн амьдралыг хүссэн.
- Гэр бүлээрэй гайхамшигтай ирээдүйг бүтээхийг хүссэн.
- Хүмүүст туслахыг хүссэн.
- Гэр бүлэсээ хагацаж холдохгүй байхыг л хүссэн.
- Аавтай болохыг хүссэн.
- Аз жаргалтай дурсамжуудыг үлдээхийг хүссэн.

Энэ хорвоод мэндэлж төрөөд ийм олон асуудлыг гэр бүлэсээ хүссэн. Өдийхөн жоохон амьдрал үзээгүй хүүхдүүдэд дэндуу их ачааг нуруундаа үүрүүлсэн том хүмүүс бүхэн ухаантай байгаасай.

Би гэр бүлдээ үүнийг хүсдэг \ зохион бичлэг \
Би гэр бүлдээ үүнийг л хүсдэг сэдвийн хүрээнд хүүхдүүд гэр бүлийн халуун дулаан хайр халамж, уур амьсгалыг хүсэн мөрөөдөж байсан. Хүүхдүүдийн бүтээлийн ихэнх хувь нь хайр халамжийг мэдэрч өсөөгүй байгаагаа илэрхийлсэн. Нийтлэг сэтгэгдлүүдийг жагсаан гаргавал:

- Би гэр бүлээрээ орой бүр ширээ тойрон сууж халуун хоолоо халуун дулаан уур амьсгалтайгаар идэж инээж хөөрөхийг хүсэж байна.

- Миний аав үргэлж архи уудаг тэгээд л ээж маань ганцаараа ажил хийдэг боловч аав маань ээжийн цалингаар архи авч уудаг. Тэгээд бид нар хоосон хонох ч ѿ байдаг. Аав маань архи уухгүй болох миний хамгийн том мөрөөдөл

- Би айлын томдоороо 2 дүүтэй. Гэтэл аав ээж маань намайг огтхон ч хайлрлаж халамжилж анхаарал тавьдаггүй. Би аав ээжийнхээ анхаарлыг татахын тулд буруу зүйл албаар хийдэг. Ааваа ээжээ намайг хааяа ч гэсэн анзаарч байлдаа

- Манайх хөдөө байдаг. Би сургуульд

сурахын тулд төвд айлд байдаг. Намайг үргэлж загнаж зовоодог. Тэгээд миний буруу огт байхгүй байхад шалтаг олж байгаад л намайг загинадаг. Харин миний буруутай үйлдэл байхын бол намайг зоддог. Аав ээжтэйгээ жилдээ 2-3 удаа л уулздаг. Утсаар ярих нь ч их ховор. Би зүгээр л аав ээжтэйгээл хамт байхыг хүсэж байна. энэ миний хамгийн том мөрөөдөл. Миний хүсдэг зүйл

- Би эхээсээ 6 уулаа. Манай ах эгч бүгд хүүхдийн парк орж үзсэн. Гэтэл би л ганцаараа орж үзээгүй. Аав ээж гэр бүлийнхнээсээ намайг парк оруулж өгөөч гэж хүсэж байна.

- Би гэр бүлэсээ амгалан тайван байдлыг хүсэж байна. манай аав ээж ажилдаа яваад их орой ирдэг. Тэгээд ирээд хоолоо ч иддэггүй. Тэгээд нэгнийгээ хардаж байнга хэрэлдэнэ. Өдөржин орхиж явчаад ядаж ирхээрээ хэрүүлгүй инээлдээд суухыг хүсдэг.

- Аав ээж 2 маань үргэлж хэрэлддэг бүр хааяа зодолддог. Тэгээд уурандаа надруу үргэлж уурлаж зоддог надад энэ нь маш их дарамтыг өгдөг. Ууралхаараа битгий намайг зодооч


Хүүхдүүдийн хүсдэг зүйлсийн талаар нийтлэг байдлаар авч үзэхэд ихэнх нь хайр халамж, итгэл, анхааралыг хүсч байна. Мөн ийм уур амьсгалтай байгаа нь хүүхдүүдэд маш их сэтгэлийн шарх амьдралд итгэх итгэлийг үгүй хийж байгаа нь харагдаж байна. Монголын ихэнх гэр бүлд архины асуудал нилээд байгаа нь хүүхдүүдийн бүх бүтээлээс харагдаж байгаа юм.



“ХҮҮХДҮҮДЭЭ
ХУСЭЛ МӨРӨӨДӨЛ
БИЧЭЭРЭЙ”



ХҮХДҮҮДЭЭ
ХҮСЭЛ МӨРӨӨДӨЛ
ЗУРААРАЙ





"БИ ГЭР БҮЛДЭЭ УЧНИЙГ Л ХУСДЭГ" 2017 ОНЫ
ГАР ЗУРАГ, ЗОХИОН БИЧЛЭГ, ШУЛГИЙН УЛСЫН УРАЛДААНЫ
ШИЛДЭГ БҮТЭЭЛҮҮДИЙН ЦОМОГ

УЛААНБААТАР ХОТ-2017



МАНАЙ ХАЯГ:
МОНГОЛ УЛСЫН ЗАСЛОНЫ ГАЗРЫН
ХЭРЭГКҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГЭР БҮЛ, ХУХЖЭД, ЗАЛУУЧУДЫН ХӨБЖЛИЙН
ГАЗАР
ХАЯГ: МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР-14191
БАГА ТОЙРУУ-44А ТЕРИЙН ӨМЧИЙН 11-Р
БАЙР
УТАС: (+976-51)-262814
ФАКС: (+976-51)-262109



МАНАЙ ХАЯГ: ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ ОЛОН
УЛСЫН БАЙГУУЛАГА
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, БАИНЗУРХ
ДУУРЭГ 13-Р ХОРООЛОЛ, 15-Р ХОРОО
С133-703 ЭНХТАЙВАНЫ ӨРТӨН ЧӨЛӨӨ,
49-Р БАРИЛГА СОМАНГ ПЛАЗА 4-Р ДАВХАР
УЛААНБААТАР 15160 ШУУДАНГИЙН ХАЙРЦАГ

705
УТАС: 976 70155323
ФАКС: 976 70155322



МАНАЙ ХАЯГ: ГЭР БУЛДЭЭ УЧНИЙГ Л ХУСДЭГ РАДИО FM 104.5
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, БАИНЗУРХ
ДУУРЭГ ИХ ТОЙРУУ МАМБАДЦАНГИЙН
БАРУН ТАД УЛААНБААТАР ХОТ, БАИНЗУРХ
ДУУРЭГ, МАМБАДЦАН 10А, САНСАРЫН
КОЛОНК. ШУУДАНГИЙН ХАЙРЦАГ: Ш/Х-1042,
УЛААНБААТАР 13, МОНГОЛ УЛС
ШУУД ЭФИРИЙН УТАС: (+976)-(11)-
461045
ЛАВЛАХ УТАС: (+976)-(11)- 461212
МЕССЕЖ УТАС: (+976)- 99861045

ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ ОУБЫН
ХҮҮХДИЙН ХӨГЖИЙН ХАМГААЛАЛ ХӨТӨЛБӨР



Хүүхэд бурийн сайн сайхны төлөө



"БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ Л ХҮСДЭГ" 2017
ГАР ЗУРАГ, ЗОХИОН БИЧЛЭГ, ШУЛГИЙН УЛСЫН УРАЛДААНЫ
ШИЛДЭГ БУТЭЭЛҮҮДИЙН ЦОМОГ